

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ҮЙЛДЛИЙН АРГА, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, МӨНГӨ УГААХ НИЙТЛЭГ ҮЙЛ ЯВЦ

Б.ДАВААХҮҮ

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8021 дүгээр
дамжааны суралцагч, магистрант, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, шинжийг харьцуулан судлах замаар энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн байцаалтын ажлаар шалгаж, илрүүлж буй одоогийн байдалд дүн шинжилгээ хийж эрүүгийн нөхцөл байдлыг судлан тодорхойлж мөрдөн байцаалтаар илрүүлэх, баримтжуулах арга, тактик болон эрх зүйн зохицуулалтын тулгамдсан зарим асуудлыг нэгтгэн дүгнэж цаашид боловсронгуй болгох тодорхой зарим санал, тэдгээрийг хэрэгжүүлэх механизмыг тодорхойлоход оршино.

Abstract: By comparing the concepts and characteristics of money laundering, the investigation of this type of crime is analyzed, the current situation is analyzed, the criminal situation is identified, the methods of detection and documentation, tactics and some regulatory issues are summarized and further developed. to identify some specific proposals and mechanisms for their implementation

Түлхүүр үгс: Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх арга, тактик, олон улсын туршлага.

Key word: Methods, tactics and international experience in detecting and prosecuting money laundering.

Мөнгө угаах гэмт хэрэг нь манай улсын хувьд шинэ төрлийн гэмт хэрэг учраас тухайн гэмт хэрэгтэй тэмцэх туршлага дутмаг, энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээлэл муутай байгаа зэрэг нь хэргийг шийдвэрлэж чадахгүй байдалд хүргэж байна. Тиймээс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэл явуулж туршлага бүхий улс орнуудын туршлагыг судлах, цаг минут тутам хувьсаж буй техник, технологийн шинэ шинэлэг хэрэгслийг ашиглан мөнгө угааж байгааг олж мэдэх шаардлагатай байна. Дэлхий нийт ч өнөөдөр мөнгө угаах гэмт хэргийн үйлдлийн арга, хэлбэрийг бүрэн таньж мэдээгүй байна. Энэ төрлийн гэмт хэргийг таньж мэдэх, мөрдөх аргачлалыг судалж мөрдөх ажиллагаанд хэрэглэж сурах нь гэмт хэрэгтэй тэмцэл явуулах чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнуудын нэн тэргүүний зорилт болон тулгараад байна. Тиймээс энэ талаар судлах нь олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх, энэхүү гэмт хэрэгт санаатай болон санамсаргүй байдлаар оролцох гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Мөнгө гэдэг зүйл төлбөрийн хэрэгсэл болсон үеэс магадгүй мөнгө угаах гэдэг ойлголт бий болсон байж болох талтай гэж барууны эрдэмтэн судлаачид үздэг. Учир нь мөнгө үүссэн цагаасаа эхлэн хаад ноёдод, эрх баригчдад өөрсдийн

эрх мэдэл, байр суурийг бэхжүүлэх чухал хэрэгсэл болж баян тансаг амьдрахын зэрэгцээ хуулийг ч өөрийн эрх ашигт нийцүүлэн гаргахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн байна". Мөнгө гэдэг бол өөр хооронд нь сольж арилжаалахад аливаа юмс, зүйлсийн өртгийн тэнцүүлэгчийн төгс хэлбэр, өртгийн тэнцүүлэгч байх байр суурийг баттай эзэлсэн, хэрэгцээний өртөг бүхий онцгой төрлийн бараа юм. "Money laundering" буюу мөнгө угаах гэдэг нэр томъёо нь Америкаас гаралтай бөгөөд гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах болон түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль ёсны болгох үйлдлийг хэлнэ. Харин мөнгө угаах нэр томъёолол нь сонгодог хэлбэрээрээ 1920-иод онд Америкийн хуурай хууль үйлчилж байх үед Чикагогийн мафийн толгойлогч Ал Капоне өөрийн эзэмшлийн хувцас угаалгын газруудыг ашиглан хууль бус үйлдэл (архины худалдаа, рекет)-ээр олсон орлогоо угаалгын газрын ашиг мэт харуулж байсныг "L'express" сонинд "Хувцас биш мөнгө угааж байна" гэж бичсэнээр анх гарч ирсэн гэж үздэг. АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсоныг 1974 онд огцруулж байсан "Watergate"-ийн дуулианы үеэр энэ нэр дахин гарч ирснээр дэлхий нийтэд танил болсон. Тэр үед Ричард Никсоныг дэмжих "Ерөнхийлөгчийг дахин сонгох хороо"-оор дамжуулан нууц данс ашиглан хууль бус мөнгийг Мексик рүү гуйвуулж байсан нь тогтоогдсон байна. Олон улсын түвшинд мөнгө угаах гэсэн¹ ойлголтыг өргөн хүрээнд хэрэглэдэг. Гэмт этгээдүүд хар тамхи, зэвсэг наймаалсан хууль бус мөнгөө казиногоос хожиж олсон мэт болгож угаадаг түгээмэл арга дэлгэрчээ.

МӨНГӨ УГААХ АРГА, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, МӨНГӨ УГААХ НИЙТЛЭГ ҮЙЛ ЯВЦ

Хууль бус үйл ажиллагаанаас мөнгө олж цуглуулсны дараагаар маш их хэмжээний ашиг олдог. Олон удаагийн цуврал гэмт хэргийн үр дүнд гэмт хэрэгтэн нүүр царайгаа өөрчилдөг байна. Уул овоо шиг эх үүсвэр нь үл мэдэгдэх их мөнгийг яаж хувиргах вэ? Ингэхийн тулд тэд гэмт хэрэг үйлдэн угаасан их мөнгөө хууль ёсны эх үүсвэртэй санхүүгийн олон секторт оруулан хувиргаж ул мөрийг нь баллана. Тэд улмаар шаардлагатай байгаа асуудлуудыг зоримог шийдвэрлэж хууль бус мөнгийг хууль ёсны санхүүжүүлэлт рүү өөрчлөн мөнгөө угаадаг байна. Мөнгө угаах маш олон алхам, арга техник, үйлдлүүд байдаг. Тэдгээр дотроос мөнгийг байршуулах, санхүүгийн салбарт хавчуулан улмаар нэгтгэн авах нийтлэг алхмуудыг авч үзье. Уг алхмууд нь заавал дарааллын дагуу үйлдэгдэх ёстой гэсэн хатуу дүрэм байхгүй бөгөөд аль ч алхмуудыг гүйцэтгэж болдог ба эдгээрийн аль нь ч мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дангаараа агуулж болдог.

Мөнгө угаах 3 алхам: Байршуулах, Хавчуулах, Нэгдэх хэлбэртэй байдаг. Эдгээрийг тус бүрд авч үзье. Үүнд:

¹ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал" олон улсын валютын сангийн семинар 2004.05.05

Байршуулах: Мөнгө угаагчид мөнгөө хууль бус санхүүжүүлэлтэнд оруулан тараан байршуулдаг байна. Ингэхдээ их хэмжээний бэлэн мөнгийг хүний анхаарал бага татахуйц бага мөнгөн дүнд хуваан шууд банкны дансанд байршуулах буюу эсвэл мөнгөний хэрэгслийн сери (чек, төлбөрийн даалгавар гэх мэт) худалдан авч хэсэг хугацааны дараа бэлэн мөнгө болгон өөр газрын банкны данснуудад байршуулдаг. Гэмт хэргийн үйл ажиллагаанаас олсон мөнгөн орлогоо өөр газар руу шилжүүлэн чанарыг өөрчлөн санхүүгийн системд байршуулдаг. Энэ алхам нь эмзэг ба хамгийн төвөгтэй юм. Маш их хэмжээний бэлэн мөнгийг нуухад төвөгтэй байдаг ба их хэмжээний дүнтэй байх нь дундаж хэмжээний банк, казиногийн теллерүүдийн анхаарлыг татдаг байна.

Байршуулах алхмын хувьд түүнийг олж илрүүлэх хэрэгцээ шаардлага нь гэмт хэргийн улмаас бий болон үүссэн бэлэн мөнгийг найдвартай байршуулж болох санхүүгийн систем рүү оруулдаг байна.

Энд бэлэн мөнгөний хуримтлагдсан хэмжээнээс хамааран санхүүгийн системд байршуулах эцэс төгсгөлгүй ажил хийгддэг. Бэлэн мөнгийг ердийн хэлбэрээр данс руу орлогодож, үнэт эдлэлийн гэх мэт өндөр үнэтэй бараа борлуулдаг дэлгүүрүүдэд чекээр бэлэн мөнгө солиулан бизнес хийж хувиргана. Дараа нь бэлэн мөнгөөрөө мөнгөний няравыг худалдан авч дахин чекүүдээ солиулдаг байна.

Хавчуулах: Тухайн үйлдэл нь байршуулсан мөнгийг шилжүүлгийн цуваа давтамжийн тоо, нийлмэл байдал болон ижил төстэй олон удаагийн хууль ёсны санхүүгийн үйл ажиллагааны цогц байдаг Ерөнхийдөө хавчуулах алхамд оруулахдаа мөнгө гуйвуулан шилжүүлэх, өөрчлөхдөө банк, санхүүгийн салбарт санхүүжүүлэлт хийх, эсхүл олон тооны дансуудыг ашиглаж хууль бус мөнгөнийхөө гарал үүслийг халхавчилдаг. Нийгмийн хамгийн өргөн хүрээг хамардаг алхам нь хавчуулах алхам байдаг.

Нэгтгэх: Мөнгө угаах эхний хоёр үе шатанд гэмт хэргийн замаар олсон мөнгөн хөрөнгийг амжилттай боловсруулсныхаа дараа гуравдахь үе шат буюу нэгтгэх үе шатанд шилжих ба энэ үе шатанд мөнгөн хөрөнгийг хууль ёсны эх үүсвэртэй болгож эдийн засагт дахин нэвтрүүлдэг. Мөнгө угаагч уг хөрөнгөөр үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгө эсвэл бизнесийн байгууллагад хөрөнгө оруулдаг. Нэгтгэх үйл явц нь хавчуулах алхмаар дамжин дэлхийн санхүүгийн салбарт тараан байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан цуглуулж, гарал үүслийг нь хууль ёсны болгох үйл ажиллагаа юм. Зөвхөн давхардуулах аргаар гэхэд хангалттай санхүүжүүлэлт хийдэг байна. Дэлхийн санхүүгийн системд нэгтгэх алхмын мөнгө угаалт их байдаг. Энэхүү алхам нь бусад алхмаа бодвол харьцангуй нийгэмд нээлттэй ил тод хэлбэрээр явагддаг. Тэд эдгээр мөнгийг санхүүгийн бүхий л салбарт оруулан зээл олгох, бондын арилжаа хийх, үнэт цаасны арилжаа хийх, банкны үнэт цаас худалдан авах, өрийн бичиг, төлбөрийн баримт, батлан

даалт гаргуулах гэх зэрэг үйл ажиллагаанд эсхүл санхүүжүүлэлт хэлбэрээр хийдэг байна.

Эдийн засаг нь хүндэрч гадаад валютын нөөц нь багасч, байгалийн баялаг нь хомсдон цаашид эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв нь бүдгэрсэн олон оронд татвараас зугтах, хуулиас гадуур байх хүсэлтэй гадаадын иргэд, аж ахуй нэгжийн хувьд маш таатай орчныг бүрдүүлсэн газар болж өөрчлөгдсөн байна. Хөрөнгө оруулагчдыг их хэмжээгээр татахын тулд маш доогуур буюу огт татвар ноогдуулахгүй учраас их хэмжээний хөрөнгөтэй хүмүүс болоод жирийн иргэд хүртэл татварын дарамтаас зайлсхийх зорилгоор уг бүс нутгийг зорьдог байна. Татвараас зайлсхийхийн тулд өөр оронд байрлахыг дэлхийн олон оронд гэмт хэрэгт тооцдоггүй учраас тэнд¹ хөрөнгөө байршуулдаг байна. Оффшор бүс нь гадаадынханд зөвхөн уг нөхцлийг үзүүлэх ба бусад орны хуулиар олгоогүй эрхийг Тэнд санал болгодог байна. Оффшор банкны нууцын тухай хууль нь хөрөнгө мөнгөө хамгаалахад маш том хамгаалалт болдог байна. Татварын таатай орчин нь маш хатуу санхүүгийн нууцлалын хуультай бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч нарыг эх оронд нь гэмт хэрэгт татах, мөрдөн шалгах ажиллагаанаас найдвартай хамгаалж чаддаг.

Халхавч компаниуд угааж байгаа мөнгийг байршуулах гол түшиц газар болдог ба мөнгө угаагч нар нь татварын таатай орчинд өнгө хадгалуулахдаа голдуу хувь хүнээр биш компанийн нэрээр данс нээж байршуулдаг. Компани нь өөрийн бизнесийн түүх, бодит үйл ажиллагаа явуулдаг хууль ёсны мэт харагдах ёстой байдаг. Компани байгуулсан тул банкинд мөнгөө хийхдээ тухайн оффшор компанийн нэр дээр хийнэ". Оффшор бүсэд үйл ажиллагаа явуулахын давуу тал нь дотоодын компанийн хууль эрх зүйн зохицуулалт болоод татвараас зайлсхийх боломж олгож байгаа юм. Тэд их хэмжээний мөнгийг дотоодын байгууллагад мэдэгдэхгүйгээр авч гаргадаг байна. Компани бүртгүүлсэн газартаа бизнес хийхгүйгээр олон улсын хэмжээнд бизнес эрхэлж байгаа нэрийдлээр оффшор компаниудын эздэд нууц байдалд байлгаж, татвар төлөхгүй байх боломжийг бүрдүүлдэг. Зарим газарт ямар ч тайлан, бүртгэл шаарддаггүй болохоор олон улсын худалдаанд эргэлдэж байгаа бараа, таваарын гарал, үүсэл, хүрэх газрыг нууцалж халхавчлахад маш тохиромжтой байдаг. Компаниуд хувьцаа эзэмшигч маягаар хөрөнгөжих боломжтой ба эзэд болон тайлан, бүртгэлийн тухай мэдээ, баримт байхгүй, хувьцаа эзэмшигч нь уг компанийн эзэн байдаг. Траст компанийг хөрөнгө байршуулахад ашиглах тохиолдолд нилээд газар аваад байна. Компаниуд нь хөрөнгөө оффшор траст компанид шилжүүлэх замаар хийдэг байна. Ямар ч зохицуулалтгүй траст компани хувьцаагаа өөр дансанд хийж, нэрээ өөрчлөх, өөр компанитай нэгтгэх, трастын баримт бичгийг сольж, данс эзэмшигчийн нэр дээр

¹ Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг тухай танилцууллага. УБ., 2007 2 Мөн тэнд үзнэ үү. Мөн тэнд үзнэ үү.

шилжүүлэх замаар хөрөнгийг нуух боломжийг олгодог байна. Тэд мөнгө угаагч нарт туслахын тулд хуурамч бичиг баримт үйлдэж үнийн нэхэмжлэх, мөнгө хүлээн авсан баримт зэргийг хийж гааль, татварын байгууллагын хяналтаас зугтахад тусладаг байна. Оффшор траст нь дайн, иргэний дайн, үймээн самуун эсвэл хууль сахиулах байгууллагын хяналт шалгалт, хэл ам ихтэй хөрөнгө оруулагчид,¹ хэрэглэгчдэд заналхийлсэн тохиолдолд хөрөнгөө шилжүүлэн байршуулах аясиллагаанд тусалдаг. Зарим мөнгө угаагч нар шилжих дансуудыг ашиглан мөнгө угаадаг ба тэд нэг газраа данс нээлгэхдээ орж ирсэн мөнгийг нэн даруй өөр дансанд шилжүүлэх бололцоог хангадаг. Хэрэв ямар нэгэн шалгалт мөрөөр нь орж ирвэл дараачийн дансны мэдээлэл өгөх үүргийг банкны ажилтнууд хүлээдэг. Орж ирсэн мөнгийг өөр дансанд шилжүүлэх үүрэг хүлээдэг учраас уг дансыг "Шилжих данс" гэж нэрлэдэг бөгөөд угаагдаж байгаа мөнгийг олж тогтооход нилээд бэрхшээл учруулдаг. Эхний данс бол зөвхөн анх эхлээд мөнгийг оруулахын тулд нээсэн данс, мөнгө орж ирээд гараад явчихдаг. Мөнгө угаагчдын зарим нь өөрийн гэсэн банкттай байдаг. Тэд банкийг худалдан авч түүгээр дамжуулан мөнгө угааж байгаад хэрэгтэй үед нь хууль сахиулах байгууллагын хяналт шалгалтаас зугтахын тулд банкаа хаах, гүйлгээний талаархи мэдээллийг устгах зэрэг аргыг хэрэглэдэг. Оффшор арал дээр л гэхэд 300 орчим ийм банк байх тохиолдол байдаг ба зөвхөн 10 хувь нь жинхэнэ банкны үүрэг гүйцэтгэдэг байна. Зуучлалаар дамжуулан мөнгө угаах арга бий бөгөөд ихэнхи тохиолдолд хуульчдыг ашиглах ба нууцлалын хуулийн дагуу харилцагчаа хамгаалж чаддаг. Мөн харилцагчийн тоог нэмэгдүүлэх зорилгоор оффшор төвүүдийн брокерууд, төлөөлөгч нарыг зуучлагч болгон ашиглаж мөнгө нууцаар байршуулдаг байна. Мөнгө угаахаар мэргэшсэн хүмүүсийн тоонд нягтлан бодогч нар, хуульчид, хувийн банкны үйлчилгээ эрхлэгчид орох бөгөөд тэд гэмт хэрэгтнүүдэд мөнгө угаахад туслан ямар ч шалгалтгүйгээр мөнгийг байршуулан, холбогдох байгууллагад үйлчлүүлэгч нарыгаа мэдээллийг өгдөггүй. Оффшор зарим санхүүгийн байгууллагууд хуурамч инвойс, ачааны дагалдах бичиг, гэрчилгээ болон холбогдох баримтуудыг хуурамчаар үйлдэж, хууль бус арилжааг хууль ёсны мэт харагдуулах бүх арга хэмжээг авдаг байна". Мөнгө угаахтай холбоотой халхавч компани: Олон улсын нэр томъёонд санхүүгийн салбарт өргөн хэргэлддэг "shell corporation", "nominee corporation", "domiciliary corporation" гэх үгнүүд нэгэн ижил утга буюу "халхавч компани" гэдгийг илэрхийлдэг байна. Халхавч компани нь мөнгө угаалтын байршуулах, хавчуулах хууль бус алхмуудад хамгийн түгээмэл оролцдог байна. FATF-ийн тодорхойлсноор халхавч гэж "корпораци, үндэслэн байгуулах, трестүүд гэх мэтийг удирдахгүй харин арилжаа, Компани² үйлдвэрлэлийн бизнесүүдийг эсхүл тухайн улсад албан ёсны бүртгэлтэй

¹ Thomas P Fitch "Dictionaru of Bankink Terms" China. 2009

² Financial Action Task Forse "Annual Reports' 2005-2006

зарим арилжааны үйл ажиллагаа явуулахыг ойлгоно" гэж тайлбарласан байдаг. Халхавч компаний гол зорилго нь хууль бусаар олсон орлогоо компаниудын хууль ёсны орлого мэтээр харагдуулахад оршдог байна.

Дэлхийн Гаалийн байгууллагаас мөнгө угаахтай тэмцэх загвар хуулийн төслийг боловсруулж Олон улсын банкны аюулгүй байдалтай холбоотой мөнгө угаах гэмт явдалтай тэмцэх чиглэлээр харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан байна. Гаалийн байгууллага дээр илэрдэг худалдааны гэмт хэргийн ихэнхийг мөнгө угаах тэр дотроо хар тамхины худалдаанаас олсон орлого эзэлдэг нь дэлхий нийтээр тогтоогдсон зүйл юм. Гаалийн байгууллага нь өөрөө экспорт-импортын баримт бичгийг Хянадаг, сэжиг бүхий санхүүгийн үйл ажиллагааг илрүүлдгийн хувьд мөнгө угаахтай тэмцэх чухал үүрэгтэй байдаг.

Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага болон Базелын хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу банкинд мөнгө угааж байгааг харуулах гол үзүүлэлтийн тоонд дараах зүйлс ордог байна. Үүнд: Харилцагч данс нээхгүйгээр бага хэмжээний төлбөрийн баримтыг их хэмжээний төлбөрийн баримтаар солих хүсэлт гаргах Харилцагчийн зүгээс данс нээлгүйгээр их хэмжээний валют бэлнээр солиулах хүсэлт гаргах Харилцагч нь данс нээлгүйгээр мөнгөний чек гэх мэт баримтуудыг хадгалан авах хүсэлт гаргах, Харилцагч нь данс нээлгүйгээр өөр улсруу сүлжээгээр шилжүүлэг хийх хүсэлт гарган тавих зэрэг болно. Харилцагч данс нээлгэсэн тохиолдолд мөнгө угааж болзошгүйг харуулах дараах шинж тэмдэг байдаг.

Банк харилцагчийг таньж мэдэх зайлшгүй үүрэгтэй байхаар тогтоож өгсөн байдаг. Харилцагч анх удаа банкинд хандсан, анхны гүйлгээ хийсэн мон тодорхой нэг этгээдийн эрх ашгийн үүднээс анхны гүйлгээ хийхээс эхлэн банк харилцагчийг таньж мэдэх үүрэгтэй байна.

ДҮГНЭЛТ.

Манай улс нь хөгжиж буй орны хувьд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг ихээр оруулах болсон бөгөөд түүний мөнгөний эх сурвалжийг хаанаас Хэнээс, яаж оруулж ирж байгаа нь чухал биш улс орон бүтээн байгуулалт хийж байна л гэж ойлгож байгаа дүр зураг харагдаж байна. Манай хууль сахиулах албаны алба хаагчид тэр дундаа тагнуул, цагдаа, прокурор, шүүх, өмгөөлөгч гэх мэт албан тушаалтнууд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх талаар нэгдсэн нэг ойлголт байхгүй байгаа нь бидний судалгааны ажлын явцад харагдлаа. Жишээ нь: цагдаагийн байгууллагаас угаах гэмт хэргээр зүйлчлээд эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар очход прокурор нь мөнгө угаах гэмт хэрэг биш залилан, ашиглалын гэмт хэрэг байна гэх мэтээр нэгдсэн нэг ойлголт одоо хүртэл байхгүй байна. Монгол банкны дэргэдэх санхүүгийн мэдээллийн алба нь хүн хүч муугаас Монгол Улсад 20 сая төгрөгнөөс дээших гүйлгээнүүдийн Мэдээллийг авдаг боловч түүнд анализ дүн шинжилгээ хийдэг алба нэгж байхгүй байгаагаас энэ төрлийн гэмт

хэрэг нуугдмал хэвээр байна. Дээрх дүгнэлтэнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Санал Гадаад улс орны туршлагаас суралцах, мөнгө угаах гэмт хэргийн талаар бүс нутаг хариуцсан Ази-Номхон далайн орнуудын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх бүлэгээс зохион байгуулж буй сургалт, уулзалтанд алба хаагч нарыг заавал оролцуулж байх. Гадны өндөр туршлагатай орнуудаас мэргэжилтэн урьж дотооддоо сургалт зохион байгуулж байх. Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын нэгдсэн сургалтыг явуулах. Монгол банкны дэргэдэх санхүүгийн мэдээллийн алба нь 20 төгрөгөөс дээших сэжигтэй гүйлгээг хянах компьютерийн программ зохион бүтээлгэх үйл ажиллагаандаа ашиглах. Энэ төрлийн гэмт хэрэг мөрдөх мэргэшсэн алба хаагчийг цагдаагийн хэлтэс тус бүрт шинээр бий болгож тэдгээрийг давтан мэргэшүүлэх сургалтанд хамруулах.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ хот 2015 он
3. Монгол Улсын Эрүүгийн хууль/төрийн мэдээлэл 2002.2.6.
4. Монгол банкны тухай хууль
5. Татварын хууль
6. Комментарий к Уголовному кодексу Российской Федерации. Москва, 1998 г
7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай Тэмцэх тухай хуулийн төсөл 2004 он
8. Российская Федерация Федеральный закон о противодействии легализации (отмыванию) доходов, полученных преступным путем Принят
9. Государственной Думой
10. Монгол Улсын Банк, Эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль” 1995 о Внесении с Ном, сурах бичиг